



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/122/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Н.Ариунтуяа Утас: 70432545 Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn
-------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
3.1 Төлбөрийн акт	11
3.2 Зөвлөмж	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 155
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Н.ЦЭВЭЛМАА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллагийн талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд ирсэн Tavor маркийн 139,700.0 мянган төгрөгийн тракторыг хөрөнгө бүртгэлд тусгаагүй;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 30,000.0 мянган төгрөгийн ногоон байгууламж хашаалсан хашааны ажлыг тайлант онд хийж гүйцэтгэсэн ч өглөг, авлагаар тайланд тусгаагүй;
- Балансын бараа материалын эхний үлдэгдэл дээр байгаа 12,000.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн тооцоо хийх, холбогдох эздээр төлүүлээгүй, аймгийн Засаг даргын тамгын газартай 10,234.1 мянган төгрөгийн өвс, тэжээлийн нийлүүлэлттэй холбоотой авлага, өглөгийн тооцоо нийлээгүй;
- Төсөвт тусгагдаагүй гадаад албан томилолтын 1,139.2 мянган төгрөгийг олгосон;
- Үр дүнгийн мөнгөн урамшуулал болон цалинг тушаал шийдвэргүй тооцож 2,842.5 мянган төгрөг олгосон;

8426050352

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын тамгын газар нь тайлант оныг "Төрийн албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулж, төрийн үйлчилгээг соёлтой, хүртээмжтэй, шуурхай, хүнд сурталгүй хүргэх зорилгоор төрийн цахим үйлчилгээний зохицуулах газраас шилэн тайлан байршуулах сайт www.gov.mn"-ыг хөгжүүлэн төрийн жинхэнэ албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээ хагас, бүтэн жилээр байршуулахаар зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд аймгийн ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 238.0 сая төгрөгийн өртөгтэй Баянгол багийн төв, 75.0 сая төгрөгийн өртөгтэй зөөврийн номын санг, сумын ОНХС-н хөрөнгөөр өвс тэжээл түүхий эдийн агуулахыг 175.2 сая төгрөгөөр тус тус данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 зорилго 5 хөтөлбөр, 36 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>63,966,757.23</u>	<u>78,342,976.14</u>
33	АВЛАГА	4,499,151.39	9,876,176.14
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,499,151.39	2,559,004.64
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	7,317,171.50
34	УРЬДЧИЛГАА	-	40,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	40,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,467,605.84	28,466,800.00
354	Хангамжийн материал	47,833,605.84	16,832,800.00
35410	Бичиг хэргийн материал	6,372,781.17	985,000.00
35420	Аж ахуйн материал	35,681,324.67	10,068,300.00
35470	Бусад хангамжийн материал	5,779,500.00	5,779,500.00
35600	Мал амьтад	11,634,000.00	11,634,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,402,372,986.46</u>	<u>2,792,957,505.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,402,372,986.46	2,792,957,505.66
392	Биет хөрөнгө	2,377,866,786.46	2,768,451,305.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,739,846,618.79	3,217,231,758.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	(737,712,630.46)	(834,274,889.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	329,526,000.00	369,818,049.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(130,923,266.76)	(172,628,433.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,701,107.82	272,827,569.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(174,963,300.29)	(200,986,646.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	175,148,551.54	175,148,551.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,807,322.18)	(59,735,681.82)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,051,028.00	1,051,028.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,540,000.00	1,540,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,540,000.00)	(1,540,000.00)
393	Биет бус хөрөнгө	24,506,200.00	24,506,200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	25,756,200.00	25,756,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,250,000.00)	(1,250,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,466,339,743.69</u>	<u>2,871,300,481.80</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,941,424.08</u>	<u>10,872,607.30</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,941,424.08	10,872,607.30
413	Өглөг	3,941,424.08	10,872,607.30
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,941,424.08	4,667,281.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,512,126.10
4136	Бусад өглөг	-	2,693,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,693,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,462,398,319.61</u>	<u>2,860,427,874.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,462,398,319.61	2,860,427,874.50

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	607,714,368.00	607,714,368.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,625,798,980.65	2,023,828,535.54
51210	Өмнөх үеийн үр дүн	1,625,798,980.65	1,639,006,480.61
51220	Тайлант үеийн үр дүн	-	384,822,054.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	228,884,970.96	228,884,970.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,466,339,743.69</u>	<u>2,871,300,481.80</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,538,425,480.22	1,980,206,457.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	123,578,271.82	618,499,105.93
120	Нийтлэг татварын бус орлого	123,578,271.82	618,499,105.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	605,000.00	2,308,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	122,973,271.82	616,190,605.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,414,847,208.40	1,361,707,352.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	340,386,708.40	264,484,507.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	340,039,048.40	264,484,507.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	347,660.00	-
1330	Төсвийн захирагчдаас	1,074,460,500.00	1,097,222,845.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,074,460,500.00	1,097,222,845.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,587,053,643.02	1,585,314,516.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,479,886,976.30	1,371,044,748.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,185,037,176.30	1,324,096,761.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	636,974,335.23	754,670,940.86
210101	Үндсэн цалин	363,547,358.06	428,478,929.04
210102	Нэмэгдэл	196,392,577.17	272,435,961.82
210104	Урамшуулал	45,354,400.00	28,016,050.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,680,000.00	25,740,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,776,432.69	94,125,824.69
210201	Тэтгэврийн даатгал	54,142,818.49	64,147,029.96
210202	Тэтгэмжийн даатгал	6,268,039.35	7,442,687.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,134,019.68	3,721,343.98
210204	Ажилгүйдлийн даатгал	3,005,629.43	3,721,343.98
210205	Эрүүл мэндийн даатгал	12,225,925.74	15,093,418.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,078,400.00	128,576,881.71
210301	Гэрэл, цахилгаан	7,234,800.00	8,264,389.71
210302	Түлш, халаалт	124,843,600.00	119,832,492.00

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	-	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,381,840.00	49,299,906.77
210401	Бичиг хэрэг	3,149,700.00	10,981,781.17
210402	Тээвэр, шатахуун	17,605,040.00	31,707,275.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,074,600.00	2,897,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	552,500.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	3,713,800.00
2105	Нормативт зардал	496,200.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	496,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,790,699.84	-
210602	Тавилга	1,999,999.92	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000.00	-
210604	Урсгал засвар	2,473,699.92	-
2107	Томилолт, зочны зардал	7,510,500.00	6,751,200.00
210702	Дотоод албан томилолт	7,510,500.00	6,751,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,404,568.40	36,758,317.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,715,868.40	36,175,662.17
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	346,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	192,655.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	34,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	701,200.00	10,000.00
210807	Газрын төлбөр	307,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,624,200.14	253,913,690.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,601,150.00	25,169,990.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,343,650.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	216,679,400.14	228,743,700.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	294,849,800.00	46,947,987.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	294,849,800.00	19,470,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,884,800.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,320,000.00	18,870,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	228,645,000.00	600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	27,477,987.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	27,477,987.11
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	107,166,666.72	214,269,768.00
2200	Дотоод эх үүсвэрээр	107,166,666.72	214,269,768.00
220001	Барилга байгууламж	107,166,666.72	-
221001	Их засвар	-	214,269,768.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(48,628,162.80)	394,891,941.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,316,666.52	10,069,886.11
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,316,666.52	10,069,886.11

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,316,666.52)	(10,069,886.11)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(51,944,829.32)</u>	<u>384,822,054.93</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,415,452,208.40</u>	<u>1,364,015,852.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	605,000.00	2,308,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	605,000.00	2,308,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	605,000.00	2,308,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	2,308,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,414,847,208.40	1,361,707,352.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	340,386,708.40	264,484,507.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	340,039,048.40	264,484,507.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	347,660.00	-
1330	Төсвийн захирагчдаас	1,074,460,500.00	1,097,222,845.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,074,460,500.00	1,097,222,845.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,313,452,208.40</u>	<u>1,109,746,084.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,313,452,208.40	1,109,746,084.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,018,602,408.40	1,055,480,925.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	636,915,600.00	745,982,751.18
210101	Үндсэн цалин	320,186,976.34	367,274,427.76
210102	Нэмэгдэл	234,880,217.13	321,248,750.63
210104	Урамшуулал	46,782,313.25	29,067,494.18
210105	Гэрээт ажлын хөлс	35,066,093.28	28,392,078.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,612,500.00	100,148,000.00
210201	Тэтгэврийн даатгал	53,355,800.00	68,100,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,369,100.00	8,011,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,372,500.00	4,005,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,228,900.00	4,005,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,286,200.00	16,023,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,078,400.00	135,716,381.71
210301	Гэрэл, цахилгаан	7,234,800.00	12,584,229.71
210302	Түлш, халаалт	124,843,600.00	122,652,152.00
210303	Цэвэр, бохир ус	-	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,293,740.40	17,121,299.50
210401	Бичиг хэрэг	2,754,400.00	2,555,300.00
210402	Тээвэр, шатахуун	16,185,940.40	11,111,999.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,353,400.00	3,454,000.00
2105	Нормативт зардал	553,700.00	-

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,990,700.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000.00	-
210604	Урсгал засвар	1,673,700.00	-
2107	Томилолт, зочны зардал	7,510,500.00	6,751,200.00
210702	Дотоод албан томилолт	7,510,500.00	6,751,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,142,068.00	14,191,053.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,389,568.00	13,515,048.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	346,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	192,655.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	34,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	765,000.00	103,350.00
210807	Газрын төлбөр	307,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,505,200.00	35,570,240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,021,200.00	35,570,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	294,849,800.00	54,265,158.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	294,849,800.00	19,470,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,884,800.00	-
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,320,000.00	18,870,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	228,645,000.00	600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	34,795,158.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	27,477,987.11
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,317,171.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>102,000,000.00</u>	<u>254,269,768.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	102,000,000.00	254,269,768.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	102,000,000.00	254,269,768.00
2200	Дотоод эх үүсвэрээр	102,000,000.00	254,269,768.00
220001	Барилга байгууламж	102,000,000.00	-
221001	Их засвар	-	244,269,768.00
222001	Тоног төхөөрөмж	-	10,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(102,000,000.00)</u>	<u>(254,269,768.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	-----------------------------------------

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	1,625,798,980.65	2,462,398,319.61
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	1,625,798,980.65	2,462,398,319.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	13,207,499.96	13,207,499.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	1,639,006,480.61	2,475,605,819.57
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	384,822,054.93	384,822,054.93
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,714,368.00	228,884,970.96	2,023,828,535.54	2,860,427,874.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,303,075,552.00	1,069,744,857.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,151,656,168.00	1,069,744,857.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,130,845,168.00	1,050,274,857.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	801,183,800.00	745,982,751.18
210101	Үндсэн цалин	413,983,400.00	367,274,427.76
210102	Нэмэгдэл	329,438,200.00	321,248,750.63
210104	Урамшуулал	27,349,400.00	29,067,494.18
210105	Гэрээт ажлын хөлс	30,412,800.00	28,392,078.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,148,000.00	100,148,000.00
210201	Тэтгэврийн даатгал	68,100,600.00	68,100,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,011,900.00	8,011,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,005,900.00	4,005,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,005,900.00	4,005,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,023,700.00	16,023,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,434,500.00	135,716,381.71
210301	Гэрэл, цахилгаан	12,586,100.00	12,584,229.71
210302	Түлш, халаалт	123,448,400.00	122,652,152.00
210303	Цэвэр, бохир ус	1,400,000.00	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,733,400.00	16,167,500.00
210401	Бичиг хэрэг	2,908,400.00	2,555,300.00
210402	Тээвэр, шатахуун	14,114,100.00	10,158,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,710,900.00	3,454,000.00
2105	Нормативт зардал	683,200.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	683,200.00	-

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,140,400.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	494,600.00	-
210604	Урсгал засвар	1,645,800.00	-
2107	Томилолт, зочны зардал	8,902,700.00	6,751,200.00
210702	Дотоод албан томилолт	8,902,700.00	6,751,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,913,868.00	12,938,785.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,809,168.00	12,262,780.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	346,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,000.00	192,655.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	34,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	669,400.00	103,350.00
210807	Газрын төлбөр	830,300.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,705,300.00	32,570,240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,705,300.00	32,570,240.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,811,000.00	19,470,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,811,000.00	19,470,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,876,000.00	18,870,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,935,000.00	600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	151,419,384.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	151,419,384.00	-
221001	Их засвар	141,419,384.00	-
222001	Тоног төхөөрөмж	10,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,303,075,552.00	1,069,744,857.89
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,302,608,552.00	1,069,744,857.89
132001	Орон нутгийн төсвөөс	1,302,608,552.00	1,069,744,857.89
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	467,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	467,000.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	266,793,007.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,576,268.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,576,268.00
2104	Хангамж, бараа материалын зардал	324,000.00
210402	Тээвэр, шатахуун	324,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,252,268.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,252,268.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,317,171.50
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	7,317,171.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	254,899,567.50
2200	Дотоод эх үүсвэрээр	254,899,567.50
221001	Их засвар	244,899,567.50
222001	Тоног төхөөрөмж	10,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	266,793,007.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	266,793,007.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	264,484,507.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,308,500.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 291,815.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 92,779.4 мянган төгрөгийн бүртгэл тайлангийн алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүйгээс элэгдэл бодогдоогүй 6 хөрөнгийг залруулан ашиглах жилийг оруулан элэгдлийг нөхөн тайлагнасан
- Машин тоног төхөөрөмжийн эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнасныг өмнөх үеийн үр дүн рүү залруулсан
- Үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг акталж устгахтай холбоотой үүссэн гарзыг үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар бүртгээгүйг залруулсан
- Бараа материал дансны эхний үлдэгдэл зөрүүтэй байсныг залруулсан
- Урьдчилж гарсан хөрөнгө оруулалтын зардлыг шууд зардалд бүртгэснийг залруулан бүртгэсэн.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх багтамж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан. Шалгагдагч байгууллагаас тайланд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрч залруулсан санхүүгийн тайланг ирүүлсэн болно.

Залруулагдаагүй 199,035.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 199,035.8 мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрснээс 3,981.73 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 195,054.1 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Илрүүлэлт: Тус байгууллагын засаг даргад дээд шатны байгууллагын тушаал шийдвэргүй үр дүнгийн мөнгөн урамшууллыг улирал бүр тооцож 2,842,500 (Хоёр сая найман зуун дөчин хоёр мянга таван зуун) төгрөгийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй, гадаад албан томилолтын төсөв батлуулаагүй байхад 1,139,230 (Нэг сая нэг зуун гучин есөн мянга хоёр зуун гучин) төгрөгийг гадаад албан томилолтод олгосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус суманд 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Шинэ хөдөө" төслийн хүрээнд Бүгд найрамдах хятад ард улсад үйлдвэрлэгдсэн 139,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий Tavor маркийн 150 морины хүчин чадалтай тракторыг данс бүртгэлд тусгахаар аймгийн ИТХ-н тогтоол гарсан ч хөрөнгийг орлогод бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-т "бүх орлого"; Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 7 дугаар сарын 4-ны А/52 дугаар захирамжийн хавсралтыг мөрдөөгүй." гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах

3.2.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийн журам зөрчин ИТХ-н хуралдааны хоолны зардалд зарцуулсан, цагаан сарын тавгийн идээний багцыг нөөц хөрөнгөөс бэлдэн зориулалтын дагуу зарцуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна", 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах.

3.2.3 Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гэрэл цахилгаанаас тээвэр шатахууны өр төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын холбогдох заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаж, тогтмол зардлыг батлагдсан зардалд зарцуулах

3.2.4 Бараа материалын тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Балансын бараа материалын эхний үлдэгдэл дээр байгаа 12,000.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн тооцоо хийх, холбогдох эздээр төлүүлээгүй, . Ховд аймгийн Засаг даргын Тамгын газартай 10,234.1 мянган төгрөгийн өвс, тэжээлийн нийлүүлэлттэй холбоотой авлага, өглөгийн тооцоо нийлээгүй, зөрүүтэй алдаа зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 -д ” Гүйлгээ, үйл ажиллагааг үнэн зөв бүртгэх”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; , 16 дугаар зүйлийн 16.5.4-д “үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх үүрэгтэй” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өвс тэжээлийн тооцоо хийж, аймгийн ЗДТГ-тай болон холбогдох байгууллага, иргэдтэй авлага, өглөгийн тооцоог тулган баталгаажуулж, үнэн зөв бүртгэн, тайланд тусган, авлагыг үе шаттайгаар барагдуулж ажиллах

3.2.5 Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ногоон байгууламж хашаалсан хашааны ажлыг тайлант онд хийж гүйцэтгэсэн ч хашааг хөрөнгөд бүртгээгүй, хашааны мөнгийг өглөг, авлагаар санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-т "бүх орлого"; гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд авлага, өглөгийг үнэн зөв бүртгэх, хөрөнгийг тайлант онд орлогод бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-г заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Төсөвлөөгүй гадаад албан томилолтын мөнгө олгосон, тушаал шийдвэргүй үр дүнгийн нэмэгдэл олгосон.	1	3,981.7	1	3,981.7						
Тус суманд 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Шинэ хөдөө" төслийн хүрээнд Бүгд найрамдах хятад улсад үйлдвэрлэгдсэн 139,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий Tavor маркийн 150 морины хүчин чадалтай тракторыг данс бүртгэлд тусгах	1	139,700.0					1	139,700.00		
ОНХС-н хөрөнгөөр хийгдсэн ногоон байгууламж хашаалсан хашааны ажлыг тайлант онд хийж гүйцэтгэсэнч өглөг, авлагаар тайланд тусгаагүй, энэ ондоо хөрөнгөд бүртгэх	1	30,000.0					1	30,000.00		
Балансын бараа материалын эхний үлдэгдэл дээр байгаа 12,000.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн тооцоо хийх, холбогдох эздээр төлүүлэх. Ховд аймгийн Засаг даргын Тамгын газартай 10,234.1 мянган төгрөгийн өвс, тэжээлийн нийлүүлэлттэй холбоотой авлага, өглөгийн тооцоо нийлээгүй, зөрүүтэй	1	22,234.1					1	22,234.10		
Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн. /Гэрэл цахилгаанаас шатахууны төлбөр төлсөн/	1	1,670.0					1	1,670.00		
Нийт дүн	5	197,585.8	1	3,981.7	0	-	4	193,604.10	0	-

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9
Засаг даргын нөөц хөрөнгийн журам зөрчин ИТХ-н хуралдааны хоолны зардалд зарцуулсан, цагаан сарын тавгийн идээний багцыг нөөц хөрөнгөөс бэлдсэн засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй	1	1,450.0					1	1,450.0
	1	1,450.00					1	1,450.0

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								

4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		